



ХЭНГИЙ АЙМГИЙН  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 1/24

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргаа ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.2.1, 27.3.1, 27.4.3, 27.4.7 27.6, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эзэмших эрхийн гэрчилгээтэй эзэмшлийн газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй иргэдийн газарт хяналт шалгалт хийн сонсох ажиллагаа явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Балчиндорж Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Г.Хишигбаатар Хууль эрх зүй дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүн: Г.Бат Газрын даамлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

2.Сонсох ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд явуулж биелэлтийг 2026 оны 02 дугаар сарын 11-ний дотор танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын орлогч (Э.Балчиндорж)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Балчиндорж)-д даалгасугай.

ДАРГА



Н.ХАТАНБААТАР